



**СЭЛЭНГЭ АЙМГИЙН ОРХОНТУУЛ СУМЫН НУТАГТ ОРШИХ
“ДЭНЖ АЛТНЫ ШОРООН ОРДЫГ АШИГЛАХ” ТӨСЛИЙН
2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

/РД: 6470556/

УЛААНБААТАР ХОТ 2025 ОН

- БҮЛЭГ I. ТӨСЛИЙН ТОДОРХОЙЛОЛТ

1.1 ТӨСЛИЙН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Төслийн нэр:
“Дэнж алтны шороон ордыг ашиглах” төсөл

Ерөнхий үнэлгээний дүгнэлтийн дугаар:
2024/СН-14


Төсөл хэрэгжүүлэгч
“Мөнгөн нуруу” ХХК, Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар: 9011811159,
Регистрийн дугаар: 6470556, MV-022165

Төсөл хэрэгжүүлэгчийн хаяг
Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 3 дугаар хороо, Агро центр, 904 тоот, Утас: 88015024,
99109815

Төслийн байршил
Сэлэнгэ аймгийн Орхонтуул сумын нутагт хамаарагдах ба тус ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбай нь Улаанбаатар хотоос 250 км, Орхонтуул сумаас 25 км-т зайд байрлана.


Газар зүйн солбицол:

	Өргөрөг	Уртраг
1	48°42' 50 ^{II}	104°37' 27.81 ^{II}
2	48°41' 12.75 ^{II}	104°37' 27.81 ^{II}
3	48°41' 12.75 ^{II}	104°37' 0.19 ^{II}
4	48°41' 31.54 ^{II}	104°37' 0.19 ^{II}
5	48°41' 31.54 ^I	104°36' 35.59 ^{II}
6	48°42' 49.13 ^{II}	104°36' 35.59 ^{II}
7	48°42' 49.18 ^{II}	104°36' 35.63 ^{II}
8	48°42' 49.18 ^{II}	104°37' 0.26 ^{II}
9	48°42' 50 ^{II}	104°37' 0.26 ^{II}



ЗУРАГ 1.1 ТӨСЛИЙН БАЙРШЛЫГ GOOGLE-ЭЭС

Сэлэнгэ аймгийн Орхонтуул сумын нутагт орших “Дэнж алтны шороон ордыг ашиглах” төслийн
2025 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө



ЗУРАГ 1.2 ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛТЭЙ ТАЛБАЙН БАЙРШИЛ



ЗУРАГ 1.3 ТӨСӨЛ ХЭРЭГЖИХ ТАЛБАЙН ХАРАГДАХ БАЙДАЛ

1.2 ТӨСЛИЙН ХҮЧИН ЧАДАЛ

Үндэсний геологийн албаны даргын 2022 оны 08 дугаар сарын 23-ний өдрийн н/64 тоот тушаалаар алтны нөөцийг бодитой (В) зэрэглэлээр шлихээр 36.39 кг, химийн цэврээр 32.90 кг, боломжтой (С) зэрэглэлээр шлихээр 4.38 кг, химийн цэврээр 3.96 кг, нийт бодитой болон боломжтой (В+С) зэрэглэлээр шлихээр 40.77 кг, химийн цэврээр 36.86 кг-аар хүлээн авч улсын нэгдсэн тоо бүртгэлд бүртгүүлж, ил уурхайг ашиглах явцад элсний бохирдол 31.06 мян.м³ буюу дунджаар 41.78 %- иар бохирдож элсний хэмжээ 104.86 мян.м³ болж уурхайн ашиглалтын үеийн элсний хаягдал 0.53 мян.м³ буюу дунджаар 0.708 % байх ба үйлдвэрлэлийн В зэрэглэлээр

344.9 мг/м³-ийн дундаж агуулгатай 104.9 мян.м³ элс, шлихээр 36.16 кг, цэврээр 32.69 кг алтны нөөц байна.

Ил уурхайгаас 104.9 мян.м³ элс олборлож 32.69 кг алт олборлохоор тооцоолсон бөгөөд байгаль хамгаалах болон нөхөн сэргээлтийн зардалд нийт

108.92 сая.төг төлөвлөж хөрөнгө оруулалтаа ашиглалтын 2.5 жил хугацаанд нөхөхөөр тооцсон бөгөөд уурхайд нийт 47 хүнийг ажлын байраар хангах юм.

1.3 ОРДЫН НЭЭЛТ

Тус алтны шороон орд нь хөрс хуулалтын хэмжээ бага, ус хуримтлагдах нөхцөл сайн зэргийг үндэслэн ордын хамгийн нам дор хэсэг буюу В-I блокт нээлт хийхээр төлөвлөсөн байна. Талбайн хучаас хөрсний зузаан дунджаар 10.5 м, элсний зузаан

0.74 м байх ба талбайн гадаргуугын налуу баруунаас зүүн зүг рүү хөндлөн чиглэлд 5°, суналын дагуу харьцангуй тэгш байна. Нээлтийн үндсэн ажилаар В-I блокийн талбайн хөрсийг хулж, элсний таазыг бүрэн нээнэ. В-I блокийн талбайд орох траншей гаргалгүйгээр түвшингээр огтлох байдлаар хөрс хуулалтыг хийх бөгөөд огтлох траншей нэвтэрч элсний давхаргыг нээж олборлоход бэлэн болгоно.

Нээгч уурхай нь дунджаар 189 м урт, 114.7 м өргөн, 13.0 м гүн, талбайн хэмжээ

21.7 мян.м² байх ба нээх элсний давхаргын талбайн хэмжээ 10.909 мян.м², авахад бэлэн нөөцийн хэмжээ 7.074 мян.м³ элс, хөрс хуулалтын хэмжээ 255.96 мян.м³ байна. Уулын үндсэн ажлыг хийхийн зэрэгцээ бэлтгэл ажлыг мөн хийж гүйцэтгэх юм. Уулын үндсэн ажлаар хуулсан хөрсийг ашиглан эфелийн хаягдлын цөөрөм, усан сан байгуулах ба үлдсэн хөрсөөр гадаад овоолго байгуулан барилга байгууламжуудыг холбосон уурхайн ашиглалтын зам засах, шинээр гаргах ажлуудыг бэлтгэгдсэн байхаар тооцож ТЭЗҮ-д тусгасан байна.

1.4 ИЛ УУРХАЙН ОЛБОРЛОЛТ

- ОРДЫН УУЛ ГЕОЛОГИЙН НӨХЦӨЛ

Тус ордын урт болон өргөний хэмжээ бага учраас хөрс хуулалт багатай, хучаас хөрсний дундаж зузаан ордын хэмжээнд 12.89 м бөгөөд олон жилийн болон улирлын цэвдэг, намаг байхгүй. Өрөмдлөгийн цооног болон уулын малталтанд усны түвшин тогтоогдоогүй бөгөөд усгүй хуурай буюу бага зэргийн устай нөхцөлд оршиж байгаа нь уулын бэлтгэл ажил хангах, олборлолтонд хүндрэл учруулахгүй, ус хуурайшуулах, татах шаардлагагүй. Алт агуулагч давхарга нь хөрсний болон гүний устай давхцаагүй байна. Дэнжийн алтны шороон орд нь энгийн тогтоцтой нэг давхаргатайгаас гадна алтны үйлдвэрлэлийн хүрээ хөндийн дагуу чиглэлд тасралтгүй үргэлжлэн, дундаж өргөн тогтмол 280 м байгаа, алт агуулагч давхаргын дундаж агуулга босоо, хэвтээ чиглэлд огцом өөрчлөлт байхгүй, давхаргын дундаж зузаан ордын хэмжээнд 0.75 м буюу жигд байгаа зэрэг үзүүлэлтүүдээрээ ордыг 2-р бүлгийн ангилалд хамааруулах нөхцөлийг бүрдүүлсэн болно. Ордын алт агуулагч давхарга нь гранулометрийн найрлагаас үзэхэд бул чулуу багатай, -40+10 мм-ийн хэмжээтэй бүдүүн хайрганы эзлэх хувь 10 байна. Шаварлаг хэсэг 12% буюу хялбархан угаагдах гэсэн ангилалд хамаарагдаж байгаа юм. Ордыг ашиглах уул-

техникийн нөхцөлөөс үзэхэд ил уурхайн аргаар олборлолт явуулах бүрэн боломжтой байна гэж ТЭЗҮ-г боловсруулсан байна.

Ил уурхайн нөөц: Шороон ордын алттай давхаргад хүдрийн 2 биетэд геологийн нөөцийн 4 блок ба үүнээс бодитой (В) зэргээр 3, боломжтой (С) зэргээр 1 блок тус тус ялган нөөцийн тооцоог хийсэн байна. Ашиглалтын явцад элсний бохирдол 31.06 мян.м³ буюу дунджаар 41.78 %-иар бохирдож элсний хэмжээ 104.86 мян.м³ болж уурхайн ашиглалтын үеийн элсний хаягдал 0.53 мян.м³ буюу дунджаар 0.708 % байх ба үйлдвэрлэлийн В зэрэглэлээр 344.9 мг/м³-ийн дундаж агуулгатай 104.9 мян.м³ элс, шлихээр 36.16 кг, цэврээр 32.69 кг алтны нөөц байна.

ХҮСНЭГТ 1.1 НӨӨЦИЙН ТООЦОО

Хэсэгшлийн дугаар	Дундаж зузаан, м		Хэсэгшлийн талбай, м ²	Дундаж агуулга, мг, м ³	Эзэлхүүн, мян.м ³		Алт, кг		Хөрс хуулалтын итгэлцүүр
	Хөрс хуулалт	Элс			Хөрс	Элс	Бохир	Цэвр	
В-I	10.46	0.77	21814.64	456.45	228.21	16.78	7.66	6.92	13.60
В-II	12.87	0.72	40590.65	527.94	522.43	29.13	15.38	13.90	17.93
В-III	13.34	0.71	39693.33	471.04	529.62	28.35	13.36	12.07	18.68
С-I	15.12	0.92	16.125.76	295.28	243.82	14.84	4.38	3.96	16.43
Бодитой В	12.22	0.73	102.098.62	495.56	1280.26	74.26	36.39	32.90	
Боломжтой С	15.12	0.92	16.125.76	295.28	243.82	14.84	4.38	3.96	
Бүгд	12.89	0.75	118224.38	457.63	1524.08	89.10	40.77	36.86	

Ашиглалтын системийн сонголт: Ордын уул техникийн нөхцөл, ашиглах аргууд, хэтийн төлөв байдал зэргээс хамааруулж ил уурхайд авто тээвэртэй дотоод овоолго бүхий нөхөн дүүргэлттэй ашиглалтын системийг хэрэгжүүлнэ.

Ашиглалтын системийн элементүүд: Ил уурхайн ажлын хэсэгт хөрсний доголын өндөр 5 м, доголын налуу 55°, элсний доголын өндөр 1 м, доголын налуу 55° байхаар ажлын бус доголын өндөр 5 м, доголын налуу 55°, аюулгүйн тавцаны өргөн 3 м, уурхайн ерөнхий налуу 37.5° гэсэн утгуудаар авч төсөлд тусгасан байна. Ашиглалтын явцад дотоод овоолготойгоор олборлолт явуулах ба нөхөн дүүрсэн хэсэгшилд нөхөн сэргээлтийн ажлыг ашиглалттай нэгэн зэрэг явуулах ба олборлохоор бэлдсэн нөөцийн хилээс буюу ашигт давхаргын улнаас ажлын талбайн хамгийн бага өргөнөөс багагүй зайд дотоод овоолгын ёроолыг байхаар төлөвлөж уулын ажлыг явуулна. Экскаваторын ачилт нь орлын өргөнөөр явагдах ба малталт хийж буй мөргөцөгийн налуу нь аюулгүйн дүрмийн шаардлагын дагуу 45- 50°-аас ихгүй байна. Орлын өргөнийг экскаваторын утгалтын радиусыг үндэслэн тэнхлэгээс 2 тийш 30°-аар эргэлдэж ачих нөхцөлөөр /10м/ авсан байна.

Утгаж ачих паспортын байгуулалтаар хөрс хуулалт болон элс олборлох ажлын талбайн хамгийн бага өргөнийг дараах томъёогоор тус тус тодорхойлсон байна.

Ажлын талбайн хамгийн бага өргөн $B_{at \min} = A_{op} + 2C_2 + B_M + 2R_э$,

Энд: A_{op} – экскаваторын орлын өргөн

C_2 - доголын хормойгоос автосамосвал хүртэлх аюулгүйн зай B_M – автосамосволын өргөн $B_{х3}$ – автосамосвол хоорондын зай

C_1 – доголын ирмэгээс авах аюулгүйн зай $R_э$ – автосамосволын эргэлтийн радиус

Хөрс хуулалт болон элс олборлолтын ажлын талбайн хамгийн бага өргөн: B_{at}

$$B_{at \min} = A_{op} + 2C_2 + B_M + 2R_э = 10 + 2 \cdot 0.5 + 2.5 + 2 \cdot 9.5 = 33 \text{ м}$$

Энэхүү төслөөр ажлын талбайн хамгийн бага өргөн 33 м ба энэ зайд автосамосвол бүтэн эргэлт хийх, сэлгээ хийх боломжтой.

- **Ил уурхайн каледарьчилсан төлөвлөлт**

Ил уурхайн үйл ажиллагаа нь захиалагчийн техникийн даалгаврын дагуу 3 жилийн хугацаанд ашиглах бөгөөд хоногт 2 ээлжээр, ээлжийн үргэлжлэх хугацаа 12 цагаар ажиллахаар ТЭЗҮ-д тусгасан байна. Уурхайн ажиллах хоногийг дараах байдлаар үзүүлбэл:


- Жилд ажиллах хоног 183 хоног
- Үндэсний баяр, ёслолын хоног 6 хоног
- Цаг агаарын хүндрэлийн нөхцөл 4 хоног
- Хангамж-технологийн бэлэн байдал 7 хоног
- Ажиллах цэвэр хоног 166 хоног тус тус байна.

Уурхайн төслийн хүчин чадал нь 36.86 кг алт олборлохоор тооцоолсон бөгөөд уурхайн бэлэн байгаа техникийн хүчин чадалд үндэслэн ордын ашиглалтын хугацаа 3 жил байх бөгөөд нийт 1.612 сая.м³ уулын цул үүнээс 104.86 мян.м³ элс олборлож, 1.6 сая.м³ хөрс хуулна. Хөрс хуулалтын дундаж коэффициент 14.38 м³/м³ байна.

¹ ТЭЗҮ-ээс

ХҮСНЭГТ 1.2 АШИГЛАЛТЫН ЖИЛИЙН УУЛЫН АЖЛЫН ХЭМЖЭЭ

Блокын дугаар	Уулын цул, мян.м ³	Хөрс хуулалт, мян.м ³	Элс олборлолт мян.м ³	Металлын нөөц, кг /шлихээр/	Металлын нөөц, кг /цэврээр/	Хөрс хуулалтын коэффициент, м ³ /м ³
В-I	279.26	255.96	23.30	7.61	6.88	10.99
В-II	631.29	590.09	41.20	15.27	13.80	14.32
В-III	670.45	630.18	40.27	13.26	11.99	15.65
С	31.50	31.40	0.09	0.02	0.02	
НИЙТ	1612.51	1507.65	104.86	36.16	32.69	14.38



ЗУРАГ 1.4 ИЛ УУРХАЙН АШИГЛАЛТЫН ЭЦСИЙН БАЙДАЛ

- **Шимт хөрс хуулалт, овоолгын төлөвлөгөө**


Ашиглалтын явцад ил уурхайгаас 0.3 м-ийн зузаантай шимт хөрсийг хуулах ба ашиглалтын явцад нөхөн сэргээлт хийх зорилгоор уурхайн хүрээнээс 3 м-ийн зайд хөрсний овоолго байгуулна. Уурхайн нээлтээр В-I блокийн хөрсийг хуулж дотоод овоолго хийх орон зайг бэлдэх бөгөөд бэлэн болсон орон зайд дараагийн В-II блокоос хуулсан хөрсөөр дотоод овоолго үүсгэж нөхөн дүүргэх замаар хураана. Уурхайн ашиглалтын нийт хугацаанд 1251.68 мян.м³ хөрсөөр дотоод овоолго үүсгэнэ.

- **Элсний овоолгын төлөвлөгөө**

Уурхай нь хоногт 192 м² элсийг угаах ба 3 хоногийн нөөц буюу 576 м³ элсийг бэлдэн, элсний түр овоолгыг баяжуулах тоног төхөөрөмжийн элс өгөх дамжлагад ойр байгуулах ба элсний овоолго нь 3м хүртэл өндөртэй, 35° налуутай, 0.2 мян.м² талбайтайгаар байгуулна.

- **Хөрсний гадаад овоолго**

Ордын нээлтийн ажлаар дотоод овоолго үүсгэх орон зай бэлдэж хуулсан 255.96 мян.м³ хөрсөөр гадаад овоолго байгуулна. Хөрсний овоолгын эзлэх талбайн хэмжээ 23.23 мян.м², дунджаар 200 м урт, 125 м өргөн, 20 м өндөр, 35° налуу, хөрсний овоолгын эцсийн байдлыг доорх зурагт харуулав.



ЗУРАГ 1.5 ХӨРСНИЙ ГАДААД ОВООЛГЫН ПЛАН

Ашиглалтын нийт хугацаанд 1.612 сая.м³ уулын цул үүнээс 104.9 мян.м³ элс олборлож, 1.6 сая.м³ хөрс хуулна. Хөрс хуулалтын дундаж коэффициент 14.38 м³/м³ байх бөгөөд “Мөнгөн нуруу” ХХК нь өөрийн тоног төхөөрөмжөөр олборлолтын ажлыг явуулах ба хөрс хуулалт болон элс олборлолтын ажилд ижил хүчин чадалтай техник ажиллуулах нь тохиромжтой бөгөөд Shantui SD 13 маркийн бульдозер ашиглахаар төлөвлөсөн байна.

- **Тээвэрлэх процесс**

Ашиглалтын хугацаанд хөрсний дотоод овоолго руу 1251.68 мян.м³ хөрсийг дунджаар 0.2 км зайд, хөрсний гадаад овоолго руу 255.96 мян.м³ хөрсийг дунджаар 0.4 км зайд, баяжуулах цехийн талбайд хүлээн авах бункерын ойролцоо түр овоолго руу ашиглалтын хугацаанд 104.9 мян.м³ элсийг 0.28-0.35 км зайд тус тус тээвэрлэх юм. Уурхайн туслах тээвэрт түлш шатахуун, тоног төхөөрөмжийн сэлбэг хэрэгсэл, материал, хүн тээвэр зэрэг аж ахуйн хэрэглээний туслах ажлуудын тээвэрлэлт хийгдэнэ. ТЭЗҮ болон байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээнд заасны дагуу Засгийн газрын 379-р тогтоолоор батлагдсан “Тусгай зориулалтын авто зам, замын байгууламж барих, ашиглах журам”-ын хэрэгжилтийг хангаж ажиллах юм.

1.5 УУРХАЙН УС ТАТАЛТ

Тус “Дэнж”-ийн алтны шороон ордод нийт 4 шугамын дагуу 38ш өрөмдлөгийн ажил явуулахад ямар нэг цооногт хөрсний ус илрээгүй байна.

Ил уурхайд орж ирэх усны тооцоо:

Ордын нөөц бодсон талбайн ил уурхайд орж ирэх хур тунадас, болзошгүй үерийн усны хэмжээг дараах томъёогоор тодорхойлов. $Q = W / 20 = 22.125 \text{ м}^3/\text{цаг}$

W –Уурхайн талбайд хоногт орох хур тунадасны хэмжээ (болзошгүй үерээс байж болно)

$$W = F \cdot h_1 \cdot n = 29500 \cdot 0.025 \cdot 0.6 = 442.5 \text{ м}^3/\text{хоног}$$

F –Уурхайн талбай, 29500 м²

h₁-Хоногт буух хамгийн их хур тунадас, м h₁= 0.025 м

n –Ил уурхайн талбайн урсцын итгэлцүүр. Энэ итгэлцүүр 0.6-0.7 учир n =0.6-аар авав.

t -ил уурхайн усыг тасралтгүй 20 цагаар шавхах, цаг

- **Ус таталтын сонголт**

Уурхайд цуглах энэхүү 22.125 м³/цаг усыг зумпанд хуримтлуулан сонгосон насосоор шавхан зайлуулах бөгөөд Үүнд бүтээлийн найдвартай байдлыг үндэслэн ЦНСк 30-30 (5.5 кВт) гэсэн насосыг сонгон авсан байна.


- **Уурхайн талбай ба бусад байгууламжийг бороо, шар усны үерээс хамгаалах ажил**

Уурхайг тойрсон шуудууны урт 426 м, хөндлөн огтлолын талбай дунджаар 0.35 м², ёроолын өргөн 0.4 м, амсрын өргөн 1.3 м, шуудуунаас нийтдээ 151.1 м³ хөрсийг экскаватороор ухаж гарган уурхайн талд овоолж байгуулах ба мөн уурхайн тосгоныг тойруулан адил хэмжээний 185 м урттай шуудуу татаж өгөх юм. Энэхүү шуудуу гаргах газар шорооны ажил 66 м³ болж байна. Нийтдээ шуудуу гаргах ажлын хэмжээ 217 м³ байна.

1.6 ЭЛС УГААН БАЯЖУУЛАХ ТЕХНОЛОГИ

Технологийн туршилт судалгааг Сэлэнгэ аймгийн Орхонтуул сумын нутагт Туул голын баруун цутгалан тойлбын хоолойн алтны шороон ордын талбайгаас авсан бөгөөд туршилтыг “Ханлаб” ХХК гүйцэтгэсэн байна. Шигшүүрийн шинжилгээний үр дүнгээс үзэхэд 2.0 мм-ээс доош ангилалд алтны мөхлөг тогтоогдсон бөгөөд нийт 419.674 кг дээжээс 84.24 мг алт гарсан ба алтны дундаж агуулга 200.63 мг/т гарсан болно. Туршилтын үр дүнгээс үзэхэд гидрошлюзээр

баяжуулж, гүйцээн баяжуулалтыг сэгсрэх ширээн дээр явуулснаар металл авалт 90.45 %-тай, анхдагч элсийг 20 мм-ээр шигшиж ангилснаар нийт элсний 73.89 % /-20 мм/ нь гидрошлюзээр баяжуулагдаж байна.



ЗУРАГ 1.6 ТЕХНОЛОГИЙН СХЕМ

ХҮСНЭГТ 1.3
ШЛЮЗЭЭР БАЯЖУУЛСАН ТЕХНОЛОГИЙН ТУРШИЛТЫН ҮР ДҮН

Бүтээгдэхүүний нэр	Гарц, %	Алтны агуулга, г/т	Металл авалт, %
Анхдагч элс	100.000	0.321	100.0
+20 мм	26.11	-	-
-20 мм	73.89	0.434	100.00
Шлюзэн дээр баяжуулах -20 мм			
Баяжмал	0.09	436.17	90.45
Хаягдал	73.80	0.05	9.55
Нийт	73.89	0.434	100.00

Туршилтын үр дүнгээр 0.09 %-ийн гарцтай, 90.45 %-ийн металл авалттай баяжмал гарган авна.

- Тунаах машинаар баяжуулсан технологийн туршилт


Алт агуулсан элсийг 20 мм-ээр ангилж шигшсэний дараа -20 мм-ийн фракцыг тунаах машинаар баяжуулан, гарсан баяжмалыг сэгсрэх ширээгээр гүйцээн баяжуулснаар металл авалт 91.65 % байх ба анхдагч элсийг 20 мм-ээр шигшиж ангилснаар нийт элсний 73.87 % /-20 мм/ нь тунаах машинаар баяжуулагдаж байна.

ЗУРАГ 1.7 ТУНААХ МАШИНААР БАЯЖУУЛСАН ТЕХНОЛОГИЙН ТУРШИЛТ ЯВУУЛСАН СХЕМ



ЭЛС УГААН БАЯЖУУЛАХ ТЕХНОЛОГИ

Элс угаах тоног төхөөрөмжийн хувьд хүндийн хүчний тоног төхөөрөмжийг ашиглах ба ангилан ялгах болон хоригт цоргоны хослол, гүйцээн баяжуулалтанд баяжуулах ширээ гэсэн үндсэн тоног төхөөрөмжийг ашиглана. Элсний том ангилалд байгаа наалдцыг усаар угаан шигшиж ангилсны дараа алт агуулсан нарийн ширхэгтэй ангиллыг хоригт цоргоор баяжуулан алттай шлихийг ялгаж авах бөгөөд угаах төхөөрөмжөөс ялгасан шлихийн баяжмалыг гүйцээн боловсруулна.



ЗУРАГ 1.8 ЭЛСИЙГ УГААХ ТЕХНОЛОГИЙН ЕРӨНХИЙ СХЕМ

Ордын элсийг угаан баяжуулах цехийн хүчин чадал 29.2-40.3 мян.м³, цагийн хүчин чадал 20.0 м³ байна.

ХҮСНЭГТ 1.4 ЭЛС УГААН БАЯЖУУЛАХ ХЭСГИЙН АЖИЛЛАХ ГОРИМ

№	Ажиллах горим	1 жил	2 жил	3 жил	Нийт
1	Хуанлийн хоногийн тоо	365	365	365	365
2	Жилийн хуанлийн цаг	8760	8760	8760	8760
3	Хоногийн хуанлийн цаг	24	24	24	24
4	Цаг ашиглалт, %	80.00	80.00	80.00	80.00
5	Ээлжид ажиллах цаг	12	12	12	12
6	Хоногт ажиллах ээлжийн тоо	1	1	1	1
7	Жилд ажиллах цаг	1764	1460	2014	5238
8	Жилд ажиллах хоног	183.8	152.1	209.7	545.6
9	Цагийн хүчин чадал, м ³ /цаг	20.0	20.0	20.0	20.0
10	Хоногийн хүчин чадал, м ³ /хоног	192.0	192.0	192.0	192.0
11	Жилийн хүчин чадал, мян.м ³ /жил	35.3	29.2	40.3	104.7

Элс угаан баяжуулах төхөөрөмж нь аль болох зардал багатай, ашигт эрдсийг бүрэн гүйцэд ялгах үндсэн зорилготой байхаас гадна богино хугацаанд хүчин чадлаа эзэмших нөхцөл боломжийг бүрдүүлэх ёстой бөгөөд элс угаах төхөөрөмжийн хүчин чадлыг ажиллах горимоос нь хамааруулан дараах томъёогоор тооцов.

$$Q_{\text{ц}} = \frac{Q_{\text{ж}}}{N \cdot n \cdot m \cdot k} = \frac{35286}{183.7 \cdot 12 \cdot 1 \cdot 0.8} = 20 \text{ м}^3/\text{цаг};$$

$$Q_{\text{ц}} = \frac{Q_{\text{ж}}}{N \cdot n \cdot m \cdot k} = \frac{29209}{152.1 \cdot 12 \cdot 1 \cdot 0.8} = 20 \text{ м}^3/\text{цаг};$$

$$Q_{\text{ц}} = \frac{Q_{\text{ж}}}{N \cdot n \cdot m \cdot k} = \frac{40272}{209.7 \cdot 12 \cdot 1 \cdot 0.8} = 20 \text{ м}^3/\text{цаг};$$

**Сэлэнгэ аймгийн Орхонтуул сумын нутагт орших “Дэнж алтны шороон ордыг ашиглах” төслийн
2025 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө**

Энд: Qц –угаах төхөөрөмжийн цагийн хүчин чадал, м³/цаг Qж –угаах төхөөрөмжийн жилийн хүчин чадал, м³/жил N –жилд ажиллах хоногийн тоо

n –нэг ээлжийн ажиллах цаг

m –хоногт ажиллах ээлжийн тоо

k –цаг ашиглалтын коэффициент

- Технологийн схемийн тоо-чанарын үзүүлэлтийн тооцоо

Технологийн туршилтын үр дүнд тулгуурлан алтны металл авалт 90.4 % байхаар тоочанарын тооцоог дараах томьёонуудыг ашиглан гүйцэтгэсэн байна. Үүнд:

Баяжмалын минерал авалт, % $\epsilon_b = \frac{Y_b \cdot B}{a}$

Хаягдлын минерал алдалт, % $\epsilon_x = \frac{Y_x \cdot \theta}{a}$

Хаягдал болон баяжмалын гарц, % $\gamma_b + \gamma_x = 100$

Энд: ϵ_b , ϵ_x - баяжмал болон хаягдал дахь алтны хэмжээ, %

γ_b , γ_x - баяжмал болон хаягдлын гарц, %

a – анхдагч агуулга

β - баяжмал дахь алтны агуулга, гр/м³

θ -Хаягдал дахь алтны агуулга, гр/м³

ХҮСНЭГТ 1.5 УГААН БАЯЖУУЛАХ ЦЕХИЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ БАЛАНС

Бүтээгдэхүүний нэрс	Агуулга, мг/м ³	Металл авалт, %	Гарц, %	Бүтээгдэхүүн, м ³ /жил
1-р жил				
Анхдагч элс	0.34	100	100	35286
Алтны баяжмал	30857.6	90.4	0.001	0.4
Хаягдал	0.03	9.6	100.0	35285.8
2-р жил				
Анхдагч элс	0.37	100	100	29209
Алтны баяжмал	33494.6	90.4	0.001	0.3
Хаягдал	0.04	9.6	100.0	29208.5
3-р жил				
Анхдагч элс	0.33	100	100	40272
Алтны баяжмал	29762.1	90.4	0.001	0.4
Хаягдал	0.03	9.6	100.0	40272.0

- Технологийн ус- шламын тооцоо

Элс угаан баяжуулах хэсгийн технологийн ус-шлагын тооцоогоор технологийн шат дамжлага бүр дэх булингын хатуу шингэний харьцааг тодорхойлсноос гадна тооцооны үр дүнд дамжлага бүрд нэмж өгөх усны хэмжээ гаднаас авах цэвэр усны хэмжээ технологийн усны баланс зэргийг тодорхойлж гаргасан байна. Ус-шлагын тооцоонд дараах үндсэн томьёонуудыг ашигласан бөгөөд адил төстэй алтны шороон ордын элс угаан баяжуулж байгаа үйлдвэрүүдийн практик ажиллагааны өгөгдлүүдийг жишиг болгон авчээ. Ус-шлагын схемийн тооцоог хийх үндсэн томьёонууд:

Сэлэнгэ аймгийн Орхонтуул сумын нутагт орших “Дэнж алтны шороон ордыг ашиглах” төслийн
2025 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө

Бүтээгдэхүүний усны хэмжээ, м³/цаг: $W_n = R_n \cdot Q_n$

Булингын эзлэхүүн, м³/цаг: $V_n = Q_n \cdot \left(R_n + \frac{1}{\delta}\right)$

Бүтээгдэхүүний хатуулаг, %: $S_n = \frac{100}{1+R_n}$

Энд: Q_n – хүчин чадал, т/цаг

R_n – бүтээгдэхүүн дэх хатуу шингэний харьцаа, %

Δ – бүтээгдэхүүний хувийн жин, гр/см³

W_n – бүтээгдэхүүний усны хэмжээ, м³/цаг

V_n – булингын эзлэхүүн, м³/цаг

S_n – бүтээгдэхүүний хатуулаг, %

Усны зарцуулалтын тооцоог доорх хүснэгтэд үзүүлэв.

ХҮСНЭГТ 1.6 ЭЛС УГААН БАЯЖУУЛАХ ЦЕХИЙН УСНЫ БАЛАНСЫН ТООЦОО

№	Орох ус		№	Гарах ус	
	Үйлдэл	м³/цаг		Бүтээгдэхүүн	м³/цаг
1	Анхдагч элсэн дэх ус	1.6	1	+20 мм-ийн ангилал	2.8
2	Угаах төхөөрөмжинд нэмэх ус	69.2	2	Хоригт цоргын хаягдал	90.6
3	Хоригт цоргод нэмэх ус	22.7	3	Баяжуулах ширээний хаягдал	0.1
4	Баяжуулах ширээнд нэмэх ус	0.1	4	Шлихийн алт	0.0
			5	Гар тэвшний хаягдал	0.0
	Нийт	93.5		Нийт	93.5

- **Бүтээгдэхүүн гаргалтын төлөвлөгөө**

НИЙТ БҮТЭЭГДЭХҮҮН ГАРГАЛТ

ХҮСНЭГТ 1.7

№	Үзүүлэлт	Нэгж	1-р жил	2-р жил	3-р жил	Нийт
1	Нийт баяжуулах элс	м³/жил	35286.1	29208.8	40.272.4	104.767.2
2	Элсэн дэх алтны агуулга	мг/м³	0.34	0.37	0.33	0.34
3	Элсэн дэх алтны хэмжээ	кг	12.1	10.8	13.3	36.14
4	Алтны баяжмалын гарц	%	0.001	0.001	0.001	0.001
5	Баяжмал дахь алтны агуулга	мг/м³	30.857.6	33.494.6	29.762.1	31171.6
6	Металл авалт	%	90.4	90.4	90.4	90.4
7	Баяжмал дахь алт (шлихээр)	кг/жил	10.9	9.8	12.0	32.6
8	Баяжмал дахь алт (хими цэвэр)	кг/жил	9.8	8.8	10.8	29.5

ХҮСНЭГТ 1.8. НИЙТ ХАЯГДАЛ ГАРГАЛТ

№	Үзүүлэлт	Нэгж	1-р жил	2-р жил	3-р жил	Нийт
1	Нийт баяжуулах элс	м³/жил	35286.1	29209	40272	104767
2	Элсэн дэх алтны агуулга	мг/м³	0.34	0.37	0.33	0.34
3	Хаягдал дахь алтны агуулга	мг/м³	0.03	0.04	0.03	0.03
4	Хаягдлын гарц	%	100.0	100.0	100.0	100.0
5	Хаягдалд металл авалт	%	9.6	9.6	9.6	9.6
6	Хаягдал гаргалт	м³/жил	35286	29208	40272	104766
7	Хаягдал дахь алтны хэмжээ	кг/жил	1.2	1.0	1.3	3.5

- **ХАЯГДЛЫН САН**

Хаягдлын сангийн байгууламж нь далан, хаалт, хаягдлын сан, булинга дамжуулах хоолой, насосны станц зэргээс бүрдэнэ. Баяжуулах цехийн хаягдал нь 20 мм-ээс дээш ширхэглэлтэй галь, 20 мм-ээс доош ширхэглэлтэй эфель байх бөгөөд эдгээр хаягдлуудыг нийлүүлж олборлолт явуулсан ил уурхайн орон зайг дүүргэх замаар техникийн нөхөн сэргээлтэд ашиглана. Эфелээс ялгарсан усыг

**Сэлэнгэ аймгийн Орхонтуул сумын нутагт орших “Дэнж алтны шороон ордыг ашиглах” төслийн
2025 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө**

урьдчилан бэлтгэсэн нуурын тусламжтайгаар тунааж цэвэршүүлээд эргэлтийн усаар ашиглана. Элс угаалтыг гравитацийн аргаар явуулах тул хаягдал нь химийн хортой материал агуулахгүй. Гадаргад ил гарсны дараа гадаргын усны нөлөөгөөр рН-ийн тэнцвэр алдагдахгүй тул гадаргын болон гүний усны шинж чанарт сөргөөр нөлөөлөхгүй.

Хаягдлын санд хаягдах булинга өөрийн жингээр тунах ба ялгарсан усыг эргэлтийн усан сан руу насосоор шахаж, эргэлтийн усан сангаас угаах төхөөрөмж эсрэг талаас эргэлтийн усны шахуургуудыг байрлуулан угаах төхөөрөмжүүдийг усаар ханган ажиллах юм. Булинга хуримтлуулах сангийн урт, өргөний хэмжээ 200х200 м, гүн нь 2-3 м байна. Баяжуулах үйлдвэрийн хаягдал нь төслийн нийт хугацаанд боловсруулалтаас хаягдаж буй 27.3 мян.м³ галь, 77.4 мян.м³ эфель байна.

- Элс угаан баяжуулах технологийн усан хангамж

Тус ордын элс угаан баяжуулах технологийн усыг орын нөөцийн хойд зүгт 1.7 км-т байрлах Туул голоос шаардлагатай усны хэрэгцээг хангана.

Хаягдлын санд эргэлтийн усны систем ашиглан угаах төхөөрөмжийн хаягдалтай хамт хаягдсан усыг тунааж эргүүлэн угаах төхөөрөмжүүдийг эргэлтийн усаар хангах ба тухайн орон нутгийн цаг агаарын байдлаас шалтгаалан усан сангийн усанд ууршилт шүүрэлтээс болж алдагдал гардаг. Иймд уг алдалтыг гадаад эх үүсвэрээс цэвэр усаар хангаж, нуурын түвшинг тогтмол барьж байх шаардлагатай. Элс угаан баяжуулах шаардлагатай усыг тооцвол 1 м³ элс угаахад

4.0 м³ ус шаардагдана. Элс угаан баяжуулахад шаардлагатай усны 70-72 %-ийг эргэлтийн усаар, 28-30 %-ийг цэвэр усаар хангана.

ХҮСНЭГТ 1.9 ЭЛС УГААН БАЯЖУУЛАХ УСНЫ ХЭРЭГЛЭЭ

№	Нэр	Нэгж	1-р жил	2-р жил	3-р жил	Нийт
1	Цагт зарцуулах усны хэмжээ	м ³ /цаг	91.9	91.9	91.9	91.9
2	Цагт зарцуулах эргэлтийн усны хэмжээ	м ³ /цаг	66.0	66.0	66.0	66.0
3	Цагт зарцуулах цэвэр усны хэмжээ	м ³ /цаг	26.0	26.0	26.0	26.0
4	Хоногт зарцуулах усны хэмжээ	м ³ /хон	1103.3	1103.3	1103.3	1103.3
5	Жилд зарцуулах усны хэмжээ	мян.м ³ /жил	202.8	167.8	231.4	602.0
6	Жилд зарцуулах эргэлтийн усны хэмжээ	мян.м ³ /жил	145.5	120.4	166.0	431.9
7	Жилд зарцуулах цэвэр усны хэмжээ	мян.м ³ /жил	57.3	47.4	65.4	170.1

ТУУЛ ГОЛЫН ОЛОН ЖИЛИЙН ДУНДАЖ УРСАЦ

Туул гол -Улаанбаатар харуул							Өнгөрөлт -Q, /м ³ /с/				
Он/Сар	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017	2018	2019	2020
I	0.01	0.00	0.00	0.00	0.01	0.05	0.05	0.03	0.03	0.07	0.04
II	0.00	0.00	0.00	0.00	0.00	"	"	"	"	"	"
III	0.00	0.00	0.00	0.00	0.01	0.13	0.10	0.09	0.71	0.02	0.10
IV	1.67	3.96	0.72	1.96	2.21	5.39	2.35	2.11	22.33	3.99	3.79
V	22.30	31.00	23.80	12.10	41.00	7.61	19.75	8.87	17.74	13.59	7.08
VI	14.00	33.50	26.00	34.60	41.70	8.06	32.35	4.90	14.36	11.64	17.09
VII	11.30	40.85	77.60	49.30	91.30	12.48	44.88	6.61	79.96	54.19	71.30
VIII	24.50	16.39	71.50	80.20	36.90	30.35	38.04	40.62	77.50	96.18	82.06
IX	12.38	11.28	38.66	54.54	19.67	13.49	24.17	28.05	77.21	35.99	50.56
X	6.53	6.45	17.50	16.00	11.20	8.55	17.46	14.46	49.22	12.70	18.06
XI	1.50	2.00	3.52	3.44	3.25	2.48	3.67	3.05	10.49	4.62	4.95
XII	0.02	0.13	0.27	0.36	0.69	0.39	0.78	0.38	1.05	1.22	0.84

Тайлбар: /"/ -ёхх-ёроолдоо хүртэл хөлдсөн/
/-/-Хэмжилт хийгдээгүй

1.7 ДЭД БҮТЭЦ

- Цахилгаан хангамж

Уурхайг дизель-цахилгаан станц ашиглан цахилгаан эрчим хүчээр хангах бөгөөд дизель станцыг баяжуулах цехийн талбайд байрлуулан хөдөлгөөнт-дизель- цахилгаан станц ашиглана. Уурхайн хэрэглэгчдийг тэжээх зорилгоор 84 кВт хүчин чадалтай 230/400В-ийн хүчдэл гаргадаг зөөврийн дизель цахилгаан станцаас кабелиёрар холбогдож тэжээгдэнэ. Ил уурхайн, угаан баяжуулах хэсэг, хотхон болон бусад ашиглалтын туршид цахилгаан эрчим хүч хэрэглэх цахилгаан хэрэглэгчдийн цахилгаан ачаалал, тэдгээрийн цахилгаан эрчим хүчний зарцуулалтыг тооцоход гол хэрэглэгчид нь:

- Баяжуулах цех
- Хотхон
- Засварын газар

Ил уурхайн хувьд засварын газрын тоног төхөөрөмжүүд болох суурь машин, цахилгаан засварын аппарат, слесарь механикийн тоног төхөөрөмж, гагнуурын аппарат зэрэг хэсэг байх болно. Төслийн цахилгаан ачааллын тооцоог дараах хүснэгтэд үзүүлэв.

ХҮСНЭГТ 1.10

УУРХАЙН ЦАХИЛГААН АЧААЛЛЫН ТООЦОО

№	Хэрэглэгчийн нэр	Тоо, ш	P _{ном} , кВт	ΣP _{ном} , кВт		cosφт	tgφт	Pт, кВт	Qт, кВАр
А. Баяжуулах цех									
1	Элс угаан баяжуулах төхөөрөмж	1	11	11	0.88	0.78	0.8	9.68	7.74
2	Баяжуулах ширээ	1	0.4	0.4	0.86	0.8	0.75	0.34	0.26
3	Эргэлтийн усны насос /ZDB-15/	1	7.5	7.5	0.85	0.76	0.86	6.38	5.48
4	Эргэлтийн усны насос /ZDB-15/	1	7.5	7.5	0.76	0.73	0.94	5.70	5.36
5	Гүний усны насос	1	6.3	6.3	0.85	0.8	0.75	5.36	4.02
6	Ус таталт насос	1	5.5	5.5	0.85	0.8	0.75	4.68	3.51
7	Тооцогдоогүй хэрэглэгчид	1						3.21	2.64
	Дүн /А/							35.34	29.00
Б. Засварын газар									
8	Суурь машин	1	3.0	3.0	0.82	0.72	0.96	2.46	2.36
9	Цахилгаан засварын аппарат	1	2.2	2.2	0.83	0.78	0.8	1.83	1.46
10	Гагнуурын аппарат	1	5.0	5.0	0.86	0.45	1.98	4.30	8.51
11	Слесарь-механик	1	1.5	1.5	0.7	0.78	0.8	1.05	0.84
12	Тооцогдоогүй хэрэглэгчид /10%/	1						0.96	1.32
	Дүн /Б/							10.60	14.49
В. Уурхайн кемп									
13	Уурхайн захиргаа /оффис/		10	10	0.97	0.93	0.4	9.70	3.88
14	Ажиллагсдын байр		8	8	0.93	0.94	0.37	7.44	2.75
15	Хоолны газар /Гал тогоо/		15	15	0.85	0.93	0.39	12.75	4.97
16	Ахуй үйлчилгээ, усны газар		5	5	0.8	0.94	0.37	4.00	1.48
17	Тооцогдоогүй хэрэглэгчид /10%/							3.39	1.31
	Дүн /В/ Дүн /А+Б+В/							37.28 83.22	14.39 57.89

- Уурхайн барилга байгууламж

Төслийн хугацаанд ажилчдын хотхонд 47 хүн байрлах бөгөөд амрах байр 10 ш, удирдлагын байр 1 ш, гал тогоо, засварын газар, хүнсний агуулах, ахуйн үйлчилгээний 1 ш контейнэр, спортын талбай, харуулын байр, ил зогсоол, дэд бүтцийн шугам зэрэг байр байна. Угсрах, задлах, тээвэрлэхэд хялбар, шилжин явах боломжтой хөдөлгөөнт барилга байгууламжуудыг төлөвлөсөн байна.

- Засварын газар

Засварын цех нь сарын үзлэг үйлчилгээ болон урсгал засвар хийх боломжтой. Засварын цехийн гадна дугуй шалгах, солих, засварлах үйл ажиллагаа явуулах зорилгоор бетонон суурь бэлдэнэ.

1.8 ТӨСЛИЙН ХОГ ХАЯГДАЛ, УСАН ХАНГАМЖ

Төслийн үйл ажиллагаанаас ахуйн гаралтай болон техникийн гаралтай хог хаягдлууд үүсэж гарна. Техникийн гаралтай хог хаягдалд актлагдсан тоног төхөөрөмж, төмөр эд анги, техникийн засвар, үйлчилгээний ажилласан тос, ашиглалтаас гарсан дугуй зэрэг хог хаягдлууд хамаарч байгаа бөгөөд дээрхи хог хаягдлыг зориулалтын талбайд хадгалж байх шаардлагатай.

Техникийн хог хаягдлын зарим хэсгийг хоёрдогч түүхий эдийн байгууллагад тушааж үлдсэн хэсгийг ахуйн хаягдлын цэгт зайлуулж тушаадаг байна. Харин ахуйн хог хаягдлыг уурхайн нутаг дэвсгэрт түр хадгалаад Сэлэнгэ аймгийн Орхонтуул сумын Засаг даргын тамгын газартай хийсэн Уул уурхайн аж ахуйн нэгжийн хуурай хог хаягдал тээвэрлэх гэрээний дагуу сумын төвийн төвлөрсөн хогийн цэг рүү Хог хаягдлын тухай хуулийн холбогдох заалтыг дагуу зайлуулж байх шаардлагатай.

Уурхайгаас хоногт $47 \text{ хүн} \times 0.5 \text{ кг} = 23.5 \text{ кг}$ ашиглалтын жилийн хугацаанд: $166 \text{ хон} \times 23.5 \text{ кг} = 390.100 \text{ кг}$ буюу 39.1 тн хатуу хог хаягдал гарах юм.

Иймд ахуйн хог хаягдлыг ангилан хадгалах савнуудыг ажилчдын байрны орчинд байршуулж, хог хаягдлын ангилгааны тэмдэгжүүлэлт хийж, ахуйн болон техникийн зарим хог хаягдлыг (техникийн тосоор бохирдсон хөрс, хайрга) ачуулах хүртэл хугацаанд хог хаягдлыг нутаг дэвсгэрт түр хадгалах цэгийг байгаль орчинд халгүй аргаар зохион байгуулж, 2017 оны шинэчлэгдэн батлагдсан Хог хаягдлын хууль, БОАЖЯ-аас 2017 оны 12-р сарын 25-ны өдрийн А/368 тоот энгийн хог хаягдлын норматив хэмжээг тогтоох аргачлал, Хог хаягдал тээвэрлэх, хураамж төвлөрүүлэх гэрээг байгуулж ажиллах шаардлагатай. Төсөл хэрэгжүүлэгч нь дараах зурагт үзүүлсэн зориулалтын хогийн савыг байрлуулах шаардлагатай.




ЗУРАГ 1.9 ЗОРИУЛАЛТЫН ХОГИЙН САВ

Мөн ордын үйл ажиллагаанаас техникийн ажилласан тос, тосолгооны материал, хаягдал дугуй зэрэг аюултай хог хаягдал үүсдэг ба эдгээрийг техникийн хог хаягдал хадгалах цэгт түр хадгалж байгаад дахиврын үйлдвэр болон хоёрдогч түүхий эд боловсруулагч аж ахуйн нэгжид шилжүүлж байх шаардлагатай байна.

- АРИУН ЦЭВРИЙН БАЙГУУЛАМЖ БАЙГУУЛАХ

Хүний биеэс ялгарч байгаа хаягдал болон ахуйн бохирыг байгаль орчинд халгүй байдлаар шийдэхийн тулд сайжруулсан нүхэн жорлон, угаадасны нүх барих шаардлагатай ба түүнд тавигдах шаардлага нь доор дурдсанчлан байна.



ЗУРАГ 1.10 САНАЛ БОЛГОЖ БУЙ САЙЖРУУЛСАН НҮХЭН ЖОРЛОН

/Агааржуулалттай, Үнэргүй, ялаагүй, Цэвэрлэхэд хялбар, Суллах, соруулах боломжтой, Аюулгүй, илүү тохь тухтай, Хүүхдийн бүхээг, суултууртай, Бохир усны цооногтой, Ажиллагсдын эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй, Байгаль орчинд сөрөг нөлөөгүй/

Хамгийн тохиромжтой, эрүүл ахуйн шаардлага хангасан бие засах газар нь “Агааржуулалттай бие засах газар” юм. Энэ нь үнэргүй, ялаагүй, аюулгүй, барилга нь хямд, гаднаас хүн харах, шагайх боломжгүй зэрэг давуу талуудтай байна. Бие засах газрын эзэлхүүний 70-80% дүүрсэн үед зориулалтын био ялзруулагч ашиглан техник хэрэгслээр соруулж, тогтоосон цэгт хаяна. Цооногт хатуу хог хаягдал хийхийг хориглоно.

Сайжруулсан нүхэн жорлон: Монгол улсын стандарт MNS 5924:2015 “Нүхэн жорлон, угаадасны нүх”-ийн ерөнхий шаардлагын дагуу дараах жорлонг барьж ашиглах нь зүйтэй.

Жорлонгийн бүхээг, салхивчийн хоолой: Хүмүүс бие засахад тохиромжтой хэмжээг хангасан, чанар, стандартын шаардлага хангасан материалаар хийсэн тоноглол хийц байна. Бүхээгний хана, дээвэр, тэдгээрийн уулзвар зай завсаргүй, хаалга нь бүрэн онгойж хаагдаж байхаар, цэвэр, өнгө үзэмжтэй хийгдсэн, тааз, хана, хаалганы дотор, гадна талыг будаж шохойдсон байх ба халдваргүйтгэх, угааж цэвэрлэхэд тохиромжтой материалаар өнгөлгөө хийгдсэн байна. Жорлон угаадасны нүхнээс бохир агаарыг өөрийнх нь урсгалаар гадагш зайлуулах малгайв ч бүхий хоолой. Салхивчийн хоолой нь бүхээгийн ар талын ханын гадна талын дунд суудлын харалдаа байрлуулсан байна.

